

МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ГЭРЭЭ

..... оны - р сарын – ны өдөр

№

Энэхүү **Мөнгөн хадгаламжийн** гэрээ (цаашид “**Гэрээ**” гэх)-г

Монгол Улсын Иргэний хуулийн 454-456 дугаар зүйлүүд, Банкны тухай хуулийн 9 дугаар зүйл, “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль”-ийн 2 дугаар бүлгийг тус тус үндэслэн,

Нэг талаас 14210 Энхтайваны өргөн чөлөө 19, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Улаанбаатар, Монгол Улс хаягт орших Худалдаа, хөгжлийн банк, (цаашид “**Банк**” гэх),

Нөгөө талаас тоот регистрийн дугаартай овогтой (цаашид “**Хадгалуулагч**”, хамтад нь “**Талууд**” гэх) нь банкнаас зарласан хадгаламжийн хүү, хугацааг хүлээн зөвшөөрч дор дурдсан нөхцлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Гэрээний зүйл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь банк хадгалуулагчийн хүсэлтээр мөнгөн хөрөнгө (цаашид “**Мөнгөн хадгаламж**” гэх)-ийг нь хадгалах, түүнийг хадгалуулсан буюу эрх бүхий этгээдэд эргүүлэн гэрээнд заасны дагуу хүүгийн хамт өгөх болон талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гэрээнд хэрэглэгдсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.2.1. “**Иргэний бичиг баримт**” гэж мөнгөн хадгаламжийн данснаас гүйлгээ хийхэд зайлшгүй шаардлагатай хадгалуулагчийг төлөөлж чадах (иргэний үнэмлэх эсхүл хүчин төгөлдөр гадаад паспорт хэрэв хадгалуулагч нь гадаадын иргэн бол тухайн улсын иргэний үнэмлэх болон паспорт) баримт бичгийг;

1.2.2. “**Дансны пин код**” гэж харилцагч хадгаламжийн дансаараа дамжуулан хийж буй төлбөр тооцооны аюулгүй байдал, нууцлалыг хангах зорилгоор банкинд өгсөн 4 оронтой тоог;

1.2.3. “**Соронзон тууз**” гэж харилцагчийн дансны мэдээллийг агуулсан, хадгалуулагчийг таних зорилго бүхий хадгаламжийн дэвтрийн хэвлэмэл туузыг;

1.2.4. “**Хугацаатай мөнгөн хадгаламж**” гэж тодорхой хугацаа зааж хадгалуулсан мөнгөн хадгаламжийг;

1.2.5. “**Хугацаагүй мөнгөн хадгаламж**” гэж тодорхой бус хугацаагаар хадгалуулсан мөнгөн хадгаламжийг;

1.2.6. “**Урьдчилсан хүүт мөнгөн хадгаламж**” гэж гэрээний хугацаанд хадгалуулагч орлого, зарлагын гүйлгээ хийхгүй байх үүрэг хүлээж, 1 сар хадгалуулсаны дараагаас бодогдсон хүүг түүний заасан дансанд шилжүүлэн авч болох нөхцөлтэйгээр хадгалуулсан мөнгөн хөрөнгийг;

1.2.7. “**Хамтран эзэмшигч**” гэж хадгалуулагчийн дансан дахь мөнгөн хөрөнгийг хадгалуулагчаас эрх олгосон хэмжээнд захиран зарцуулах эрхтэй хадгалуулагчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээж буй хамтран өмчлөгч этгээдийг;

1.2.8. “**Итгэмжлэгдэгч**” гэж хадгалуулагчийн Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2-д заасан шаардлага хангасан хүчин төгөлдөр итгэмжлэлийн үндсэн дээр хадгалуулагчийн нэрийн өмнөөс хадгаламжийн гэрээнд гарын үсэг зурах, орлого зарлагын гүйлгээ, хадгаламжийн хугацаа сунгалт, цуцлалт зэрэг үйлдлийг хийх эрх олгогдсон этгээдийг;

1.2.9. “**Хугацаа алдалтын хүү**” гэж тодорхой хугацаа зааж хадгалуулсан хадгаламжийн гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд бодогдох хүүг;

1.2.10. “**Өв залгамжлагч**” гэж хадгалуулагч нь нас барсан болон нас барсан гэж зарлагдсан тохиолдолд мөнгөн хадгаламжийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлах эрх бүхий этгээдийг;

1.2.11. “**Хадгаламжийн дэвтр**” гэж мөнгөн хадгаламжийн орлого зарлагын гүйлгээг тэмдэглэх дэвтрийг тус тус ойлгоно.

1.2.12. “**Тэтгэврийн хадгаламж**” гэж тэтгэвэр, тэтгэмжийн дэвэртэй, тэтгэвэр авагчдад зориулсан хадгаламжийн дансыг хэлнэ.

1.3. Хадгалуулагч нь мөнгөн хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгөө өөрийн эрх олгосон хэмжээнд захиран зарцуулах эрх бүхий хамтран эзэмшигчтэй байхаар хүсэлт гаргасан бол хамтран эзэмшигч нь хадгалуулагчийн нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх болохыг үүгээр баталж байна.

1.4. Гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байгаа “Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл” болон түүнд цаашид орох нэмэлт, өөрчлөлтүүд нь гэрээний салшгүй хэсэг болно.

Хоёр. Мөнгөн хадгаламжийн хугацаа, дүн, түүнд хүү тооцох журам

2.1. Хадгалуулагч нь өөрийн мөнгөн хадгаламжийг мөнгөн тэмдэгтээр сарын хугацаатайгаар, жилийн хувийн хүүтэйгээр хадгалуулна.

2.2. Банк нь мөнгөн хадгаламжийн дансанд бэлэн бусаар орлого орох тохиолдолд орлогын гүйлгээг мөнгөн хадгаламжийн дансанд нийт дүнгээр нь орлогодож, дараа нь “Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу шимтгэлийг суутган авна. Хадгалуулагчийг банкинд дээр ирсэн үед хадгаламжийн дэвэрт бичилтүүдийг нөхөж хэвлэж өгнө.

2.3. Мөнгөн хадгаламжийн хугацааг хадгалуулагч хадгаламжийн данс нээж, мөнгөн хөрөнгөө байршуулсан үеэс эхлэн тооцох бөгөөд хүү бодох хугацааг хуанлийн он, сар, өдрөөр тодорхойлно.

2.4. Хугацаагүй болон урьдчилсан хүүт мөнгөн хадгаламжийн хүүг өдөр бүр хуримтлуулан тооцох бөгөөд сар бүрийн эцэст нэг удаа мөнгөн хадгаламжийн дансанд шилжүүлнэ.

2.5. Хугацаатай мөнгөн хадгаламжийн хүүг өдөр болгон хуримтлуулан тооцох бөгөөд гэрээнд заасан хугацааны эцэст мөнгөн хадгаламжийн дансанд шилжүүлнэ.

2.6. Хугацаагүй мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг банк өөрчилж, энэ тухай нийтэд мэдэгдсэнээс хойш нэг сарын дараа гэрээнд заасан хүүгийн хэмжээг өөрчлөгдсөнд тооцно. Хэрэв хадгалуулагч энэ нөхцлийг зөвшөөрөхгүй бол гэрээг цуцалж болно.

Анхааруулга: Хадгалуулагч гэрээний хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө банкинд ирж гэрээг шинэчлэх буюу хугацаа өөрчлөх хүсэлтээ бичгээр гаргана. Хэрэв заасан хугацаанд ирээгүй тохиолдолд гэрээний хугацаа дууссанд тооцож хүүг хугацаагүй хадгаламжийн хүүгээр тооцно.

2.7. Хугацаатай мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээ нь хадгаламжийн гэрээнд заасан хугацааг дуустал анх тохиролцсон хэвээр байх бөгөөд гэрээнд заасан хүүгийн хэмжээ өөрчлөгдөөгүй тохиолдолд хугацаатай мөнгөн хадгаламжид орлогын гүйлгээ хийвэл хүүг гэрээний дагуу хэвээр мөрдөнө.

2.8. Банкнаас хүүгийн хэмжээг өөрчилснөөс хойшхи хугацаанд нээсэн болон хугацаа сунгуулсан аливаа мөнгөн хадгаламжийн хувьд хадгаламжийн гэрээг шинээр байгуулна.

2.9. Хадгалуулагч хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээ дуусгавар болохоос өмнө банкинд ирж, гэрээг шинэчлэх буюу хугацаа сунгуулах өөрчлөлтийн талаар банкинд мэдэгдэх эсхүл ТиДиБи Онлайн үйлчилгээгээр мөнгөн хадгаламжийн хугацааг сунгаж болно.

2.10. Хадгалуулагч банкт байгуулсан гэрээний хугацаа дуусахад шууд үргэлжлүүлэн сунгагдаж байхаар хүсэлт гаргасан бол банк хүсэлтийг бичгээр авч, гэрээг хадгалуулагчийн хүсэлтийн дагуу сунгалт хийх ба харилцагч мөн ТиДиБи Онлайн үйлчилгээгээр дамжуулж мөнгөн хадгаламжийн хугацааг сунгаж болно. Хадгалуулагчтай байгуулсан гэрээний хугацаа дуусч сунгалт хийх үед мөнгөн хадгаламжийн хүү өөрчлөгдсөн тохиолдолд тухайн үеийн өөрчлөгдсөн хүүг дагаж мөрдөнө.

2.11. Хадгалуулагч энэхүү гэрээний 2.9, 2.10-д заасан хугацаанд банкинд хугацаа сунгуулах талаар мэдэгдэл өгөөгүй, ТиДиБи Онлайн үйлчилгээгээр хадгаламжийн хугацаа сунгах захиалга хийгээгүй бол хугацаатай мөнгөн хадгаламжийг банкт байгуулсан гэрээний хугацаа дууссан өдрөөс эхлэн хугацаагүй мөнгөн хадгаламжид тооцон, хүүг хугацаагүй мөнгөн хадгаламжийн хүүгээр тооцно.

2.12. Хадгалуулагч хугацаатай хадгаламжийн хугацаа дуусгавар болохоос өмнө зарлагын гүйлгээ гаргахдаа хадгаламж барьцаалсан зээл авах хүсэлт гаргаагүй тохиолдолд хадгаламжийн гэрээг цуцлагдсанд тооцон, гэрээ байгуулсан өдрөөс эхлэн тухайн өдрийн эцсийн үлдэгдэлд жилийн хувиар хугацаа алдалтын хүүг тооцоолон бодож олгоно. Хэрэв урьдчилсан хүүт хадгаламж бол өмнө олгосон хүүг дансны үлдэгдэлээс банк суутган авна.

2.13. Хадгалуулагч урьдчилсан хүүт хадгаламжийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийх, хадгаламжийн гэрээг хугацаанаас өмнө цуцлах эрхгүй ба энэ талаар банкт ямарваа нэгэн маргаан гаргахгүй.

2.14. Дансандаа хадгаламжийн дэвтэр холбуулсан хадгалуулагч хадгаламжийн дэвтрийг хаясан, үрэгдүүлсэн тохиолдолд салбар, тооцооны төвд, эсхүл Банкны лавлах утсаар нэн даруй мэдэгдэж, данснаас гүйлгээ хийлгэхийг зогсоолгох үүрэгтэй. Ийнхүү мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг хадгалуулагч бүрэн хариуцна. Банк хадгалуулагчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн шинээр дэвтэр олгоно.

2.15. Хадгалуулагч нь хадгаламжийн данстай холбоотой бүх төрлийн үйлчилгээг салбар, тооцооны төв харгалзахгүй авна.

Гурав. Банкны эрх, үүрэг

3.1. Банкны эрх нь:

3.1.1. Мөнгөн хадгаламжид авсан мөнгөн хөрөнгийг өөрийн гүйлгээнд хэрэглэн, түүний бүрэн бүтэн байдлыг хангах;

3.1.2. Мөнгөн хадгаламжийн хүүг дангаараа өөрчлөн тогтоох¹;

3.1.3. Хадгалуулагч болон түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд мөн эсэхийг баталгаажуулах, хадгалуулагчийн мөнгөн хадгаламжийн аюулгүй байдал, нууцлалыг хангах зорилгоор түүнээс дансны пин кодоор өөрийн эрхийг баталгаажуулахыг шаардана. Хэрэв хадгалуулагч аливаа шалтгаанаар 3 удаа дараалан пин кодыг буруу оруулсан тохиолдолд банк гүйлгээ хийхээс татгалзах бөгөөд үүнээс шалтгаалан хадгалуулагч, гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирол, зардлыг банк хариуцахгүй;

3.1.4. Гэрээний 3.1.2-д заасан эрхээ бие даан хэрэгжүүлэх;

3.1.5. Банк хадгалуулагч болон хамтран эзэмшигчийн хооронд үүссэн аливаа маргаанд хариуцлага хүлээхгүй;

3.1.6. Хуульд заасан бусад эрх.

3.1.7. Банк нь “Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу хураамж, шимтгэлийг харилцагчийн данснаас суутган авах.

3.1.8. Банк нь Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу аливаа татвар хураамжийг харилцагчийн данснаас суутгах.

3.2. Банкны хүлээх үүрэг нь:

3.2.1. Хадгалуулагчийн нэр дээр мөнгөн хадгаламжийн данс нээх;

3.2.2. Мөнгөн хадгаламжаас хадгалуулагч болон хамтран эзэмшигчийн зөвшөөрөл буюу даалгавраар гүйлгээ хийх;

3.2.3. Гэрээнд заасан нөхцлийн дагуу хадгалуулагчийн тавьсан анхны шаардлагаар түүний хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүү төлөх;

3.2.4. Мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг үнэн зөв бодож, олгох;

3.2.5. Хадгалуулагчийн дансны нууцыг хадгалах;

3.2.6. Өөрийн буруугаас учруулсан хохирлыг нөхөн төлөх;

3.2.7. Мөнгөн хадгаламжийн гэрээг нэг талын санаачилгаар өөрчлөх, хугацаанаас өмнө цуцлахгүй байх;

3.2.8. Мөнгөн хадгаламжийн дансны гүйлгээ, үлдэгдлийн талаарх мэдээллийг хадгалуулагчийн хүсэлтийн дагуу тухай бүрд нь гаргаж өгөх;

3.2.9. Хадгалуулагчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн дансны пин кодыг солих.

3.2.10. Банк нь “Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл” болон түүнд орсон нэмэлт, өөрчлөлтүүдийг тухай бүр өөрийн www.tdbm.mn цахим хуудсаар дамжуулан харилцагчид хүргэнэ.

Дөрөв. Хадгалуулагчийн эрх, үүрэг

4.1. Хадгалуулагчийн эрх нь:

4.1.1. Мөнгөн хадгаламжийн данс нээлгүүлж, хадгалуулсан мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах хэлбэрийг сонгох;

4.1.2. Хадгалуулсан мөнгөн хадгаламждаа хүүгийн орлого авах;

4.1.3. Мөнгөн хадгаламжийн гүйлгээ, үлдэгдлийг дансны хуулга болон мөнгөн хадгаламжийн дэвтэртэйгээ тулган шалгах, зөрчил гарвал тухай бүрт нь арилгуулах;

4.1.4. Мөнгөн хадгаламжийг дундаа хамтран өмчлөх, итгэмжлэл олгох;

4.1.5. Мөнгөн хадгаламжийг өвлүүлэх, гэрээслэх, бэлэглэх;

¹ Энэхүү заалт нь хугацаатай хадгаламжийн хугацааны туршид хамаарахгүй.

Анхааруулга: Хадгалуулагч гэрээний хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө банкинд ирж гэрээг шинэчлэх буюу хугацаа өөрчлөх хүсэлтээ бичгээр гаргана. Хэрэв заасан хугацаанд ирээгүй тохиолдолд гэрээний хугацаа дууссанд тооцож хүүг хугацаагүй хадгаламжийн хүүгээр тооцно.

- 4.1.6. Банкинд бичгээр хүсэлт гарган, дансны пин кодоо солих;
- 4.1.7. Банкнаас үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар шаардах, шүүхэд нэхэмжлэх.
- 4.1.8. Хадгалуулагч хүсвэл хадгаламжийн дансандаа хадгаламжийн дэвтэр болон дансны пин код холбуулахгүй байж болно.

4.2. Хадгалуулагчийн хүлээх үүрэг:

- 4.2.1. Мөнгөн хадгаламжийн дансандаа заавал байлгах **үлдэгдлийн доод хэмжээг** тогтмол байлгах;
- 4.2.2. Хадгаламжийн дансанд хадгаламжийн дэвтэр болон пин код холбуулсан бол дансны пин кодыг мартахгүй, гуравдагч этгээдэд задруулахгүй байж, банкаар үйлчлүүлэхдээ дансны пин кодоор өөрийн эрхийг баталгаажуулах, хадгаламжийн дэвтрийг зориулалтын уутанд хийж, соронзон туузыг гэмтээхгүй байх;
- 4.2.3. Хадгалуулагч хадгаламжийн дансандаа хадгаламжийн дэвтэр болон пин код холбуулаагүйгээс үүдэн гарах үр дагавар, хариуцлагыг хүлээх, банк болон хадгалуулагчид учирсан хохирлыг бүрэн хариуцах;
- 4.2.4. Хадгалуулагч нь банкны мэдээллийн санд байгаа өөрийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд банкинд мэдэгдэж мэдээллээ шинэчлэх шаардлагатай;
- 4.2.5. Банктай харилцах итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрчлөгдсөн даруйд энэ талаар банкинд нэн даруй бичгээр мэдэгдэх, ийнхүү мэдэгдээгүйгээс үүдэн гарах үр дагавар, хариуцлагыг хүлээх, банк болон хадгалуулагчид учирсан хохирлыг хариуцах;
- 4.2.6. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хийсэн гүйлгээг тогтмол хянаж байх, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлбөр тооцооны эрх, үүргээ хэрэгжүүлсэнтэй холбоотой бүхий л үүрэг хариуцлагыг хүлээх, банк болон хадгалуулагчид учирсан хохирлыг хариуцах;
- 4.2.7. Гүйлгээ, төлбөр тооцооны баримтад баталгаат гарын үсгийг дардасаар орлуулан ашиглах шаардлага гарсан тохиолдолд дардас ашигласнаас банк болон хадгалуулагчид үүсэх хохирлыг бүрэн хариуцах;
- 4.2.8. Хуульд заасан бусад үүрэг.
- 4.2.9. Харилцагч (хадгалуулагч) нь гэрээний хугацаанд харилцах данснаасаа Банкнаас тогтоосон шимтгэл, хураамжийг “Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д заасны дагуу төлөх.
- 4.2.10. Хадгаламжийн дансандаа хадгаламжийн дэвтэр холбуулсан хадгалуулагч нь онцгой тохиолдолд хадгаламжийн дэвтрэгүйгээр гүйлгээ хийж болох ба энэ тохиолдолд гүйлгээ хийснээс үүдэх аливаа хохирол, зардал, эрсдлийг бүрэн хариуцна.

Тав. Хариуцлага

- 5.1. Банк нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4, 5.6 дахь хэсгүүдэд заасан үүргээ гүйцэтгээгүй бол хадгалуулагчид гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээс хоног тутамд 0.01 хувийн алданги төлнө.
- 5.2. Хадгалуулагч хууль буюу гэрээнд заасан үүргээ зөрчсөнөөс банкинд хохирол учруулвал уг хохирол, зардлыг бүрэн хариуцна.
- 5.3. Хадгалуулагч иргэний бичиг баримтыг хуурамчаар үйлдэх, залилах, хууран мэхлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчих замаар банкинд хохирол, зардал учруулсан бол учруулсан аливаа хохирол, зардлаа дансан дахь хөрөнгө, бусад арилжааны банкинд дахь дансны хөрөнгө болон бусад хөрөнгө (хөдлөх, үл хөдлөх)-нөөсөө үл маргалдах журмаар төлнө. Энэ тохиолдолд хадгалуулагч тусгайлан зөвшөөрөл өгөх шаардлагагүй бөгөөд гэрээ нь захиран зарцуулах зөвшөөрлийг бүрэн илэрхийлэхийг талууд тохиролцов.
- 5.4. Хадгалуулагчийн өөрийн (иргэний бичиг баримтын бүрдүүлбэр дутуу, бусад мэдэгдсэн болон бусад үйлдэл, үйл ажиллагаа) болон бусад банкны буруутай үйл ажиллагаанаас болж хадгалуулагчийн төлбөр тооцоо саатсан, түүнд хохирол, зардал учирснаас үүдэн гарах хариуцлагыг банк хүлээхгүй.

Зургаа. Маргаан шийдвэрлэх

- 6.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.
- 6.2. Хэрэв 6.1-д заасан аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо. Бусад зүйл

- 7.1. Гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж, уг хадгаламжийн дансанд орлогын гүйлгээ хийснээр эсхүл ТиДиБи Онлайн үйлчилгээгээр нэвтрэх нэр, нууц үгээр баталгаажуулж, гэрээг хүлээн зөвшөөрсөн тэмдэглэгээг сонгон, данс нээгдэж, уг хадгаламжийн дансанд орлогын гүйлгээ хийснээр хүчин төгөлдөр болно.
- 7.2. Гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь адил хүчинтэй байна.
- 7.3. Энэхүү гэрээний дагуу эзэмшиж байгаа мөнгөн хадгаламжийн данс дахь дундын өмчийн хөрөнгийг хадгалуулагч болон хамтран эзэмшигч захиран зарцуулахыг үүгээр зөвшөөрч байна. Цаашид орлого, зарлагын гүйлгээ хийх, хадгаламж барьцаалсан зээл авах, цахим сувгаар дансаа удирдах зэрэг бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх бүрд мөнгөн хадгаламжийн данс дахь дундын өмчийн хөрөнгийг захиран зарцуулах зөвшөөрөл олгохгүй бөгөөд Иргэний хуулийн 108 дугаар зүйлийн 108.4 дэх хэсэгт заасан зөвшөөрөл олгогдсон гэж үзэх болно (Тайлбар: Энэ хэсэг нь хадгалуулагч хамтран эзэмшигчийн мөнгөн хадгаламжийн данс дахь хөрөнгийг захиран зарцуулах хэмжээг тусгайлан заасан тохиолдолд хамаарахгүй).
- 7.4. Мөнгөн хадгаламжийн хугацааг хадгалуулагч банктай гэрээ байгуулж, хадгаламжийн дансандаа мөнгөн хөрөнгө оруулсан үеэс эхлэн тооцох бөгөөд мөнгөн хадгаламжийн хугацаа дахин сунгагдсан, цуцлагдсан тохиолдолд хадгалуулагч банканд хүсэлт гаргаж, түүний дагуу банк хадгаламжийн дэвтрийн ард “Гэрээний нөхцөл” хэсэгт бичилтийг хийх эсхүл гэрээг дахин байгуулснаар хуулийн дагуу хүчин төгөлдөр болно.
- 7.5. Хадгалуулагч интернэт холболт бүхий мэдээллийн технологи, харилцаа холбооны төхөөрөмж (гар утас, компьютер, таблет гэх мэт) ашиглан цахим банкны үйлчилгээ (Ти Ди Би Онлайн үйлчилгээ, Мост мони үйлчилгээ гэх мэт)-ний хуудсаар дамжуулан банкинд дахь өөрийн мөнгөн хадгаламжийн дансанд бэлэн бус орлого, зарлагын гүйлгээ хийх, хадгаламжийн дансны хугацаа сунгах, цуцлах, хадгаламжийн данс шинээр нээх, хадгаламж барьцаалсан зээлийн хүсэлт гаргах, шийдвэрлүүлэх, мөнгөн хадгаламж барьцаалсан зээлийн гэрээг цахимаар байгуулах зэрэг бүх төрлийн үйлчилгээг авахдаа нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үг болон нэг удаагийн нууц дугааруудыг ашигласан нь банкинд өгсөн мөнгөн хадгаламжийн дансыг захиран зарцуулахад хэрэглэгдэх эрх бүхий этгээдийн баталгаат гарын үсгийн маягийн адил хүчин төгөлдөр байна.
- 7.6. Хадгалуулагч Банкны лавлах 19001977, 70161988, info@tdbm.mn, callcenter@tdbm.mn сувгаар дамжуулан Банкны дахь өөрийн мөнгөн хадгаламжийн гэрээний хугацааг сунгах, өөрийн эзэмшдэг хугацаатай хадгаламжийн данс руу болон өөрийн хамтран эзэмшдэг **Анхааруулга: Хадгалуулагч гэрээний хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө банкинд ирж гэрээг шинэчлэх буюу хугацаа өөрчлөх хүсэлтээ бичгээр гаргана. Хэрэв заасан хугацаанд ирээгүй тохиолдолд гэрээний хугацаа дууссанд тооцож хүүг хугацаагүй хадгаламжийн хүүгээр тооцно.**

хүүхдийн хугацаатай хадгаламжийн дансанд тогтмол шилжүүлгийн үйлчилгээнд бүртгүүлэх, энэхүү гэрээнд заасан дансанд бүртгэлтэй бүх тогтмол шилжүүлгийн үйлчилгээний хугацааг сунгах, Банкны лавлахаар бүртгүүлсэн тогтмол шилжүүлгийн үйлчилгээг цуцлах зэрэг үйлчилгээг авахдаа Банкинд бүртгэлтэй өөрийн цахим шуудангийн хаяг, утасны дугааруудыг ашигласан нь Банкинд хэрэглэгдэх эрх бүхий этгээдийн баталгаат гарын үсгийн маягийн адил хүчин төгөлдөр байна.

7.7. Гэрээний 7.1-т заасны дагуу хадгаламжийн данс нээлгэснээс хойш уг хадгаламжийн дансанд орлогын гүйлгээ хийгээгүй тохиолдолд данс нээлгэсэн өдрөөс хойш 2 сарын дараа уг дансыг хаана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Банкийг төлөөлж:

Хадгалуулагчийг төлөөлж:

Анхааруулга: Хадгалуулагч гэрээний хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө банкинд ирж гэрээг шинэчлэх буюу хугацаа өөрчлөх хүсэлтээ бичгээр гаргана. Хэрэв заасан хугацаанд ирээгүй тохиолдолд гэрээний хугацаа дууссанд тооцож хүүг хугацаагүй хадгаламжийн хүүгээр тооцно.